



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/200

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагдаагийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий Иргэний зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 2,100,000 төгрөгийг хавсралтад заасны дагуу зарцуулсугай.

2. Дээрхи урамшуулалд зарцуулах 2,100,000 төгрөг /хоёр сая нэг зуун мянга/-ийг аймгийн Хөшөөт хөгжил сангийн 2022 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний 5.21 дэх заалтаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
04 дүгээр сарын 18-ны өдрийн
А/200 дугаар захирамжийн
хавсралт

УРАМШУУЛАЛД ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ЗАДАРГАА

Д/д	Овог, нэр	Албан тушаал	Урамшууллын хэмжээ (төгрөг)
1	Ч.Цэрэнчимэд	Иргэний зөвлөлийн дарга	400,000
2	Н.Мөнхбат	Иргэний зөвлөлийн гишүүн	400,000
3	Б.Батжаргал	Иргэний зөвлөлийн гишүүн	400,000
4	А.Бямбасүрэн	Иргэний зөвлөлийн гишүүн	400,000
5	Д.Эрдэнэзул	Иргэний зөвлөлийн гишүүн	400,000
6	Үйл ажиллагааны зардалд		100,000
Нийт дүн			2,100,000

-oOo-